

ОРЮК ХАДНЫ ТҮРЭГ БИЧЭЭСИЙН ТУХАЙ

(урьдчилсан тайлан)

**Л. БОЛД, Хэл бичгийн
ухааны дэд эрдэмтэн**

О. 1984 оны зун миний бие Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангид оролцон Хөвсгөл аймагт явахдаа, Мөрөн хотын орон нутаг судлах музейн ажилтан С. Банзрагч гуайтай уулзсан юм. Тэрээр, эртний түрэг бичгийн дурсгалыг эрэн сурвалжилж яваа бидний зорилгыг мэдсэнийхээ дараа «Манай аймгийн Ринчен Лхүмбэ сумын нутаг Тэнгис голд хадны бичиг бий гэсэн сураг бий. Би өөрөө очиж үзээгүй, нутгийн ардын ярианаас үзвэл зуны улиралд бичигт хаданд хүрэх зам бэрх, явж болох ч үгүй, өвөл цагт гол ус хөлдсөн хойно мөсөн дээгүүр явбал арай хялбар очиж болно» гэлээ. Банзрагч гуайн хэлсэн мэдээ үнэн бол энэ нь Шинжлэх ухааны эргэлтэд ороогүй шинэ бичээс байх ёстой. Иймээс ч шинжилгээний ангийнхны сэтгэлийг тэр үедээ их л хөдөлгөж билээ.

Үүнээс хойш уг бичээсийг газар дээр нь очиж судлан үзэх цаг, боломж гараагүй нилээд хугацаа өнгөрлөө. Гэтэл 1986 оны 9, 10-р сард дархад нутгаар ардын дуу хөгжим, урлаг судлах зорилготой явсан шинжилгээний ангийнхнаар дамжуулан Тэнгэсийн голд буй хадны бичгийг судлан үзэхийг Цагааннуур сумын нөхөд тус хүрээлэнгийн удирдлагад хүсэлт болгожээ. Энэ үеэр би Уйгар-урианхай, мончоог хэл аялгууны материал цуглуулах зорилгоор Хөвсгөл, Ховд аймагт эрдэм шинжилгээний албан томилолтоор яваад аяны дөрөө дөнгөж мултрад байсан цаг юм. Хүрээлэнгийн захиргаа хөдөө орон нутагт ажиллаж ирсэн биднийг ямархан олз омогтой явж ирсэнтэй маань танилцах зуур, Цагааннуур сумын удирдах нөхдийн тавьсан хүсэлтийг биелүүлэх үүргийг надад даалгасан билээ. Ингээд Монгол ардын аман зохиол, монгол түрэг хэл судлаачдын анхаарлыг татаж байдаг Дархадын хотгор луу явах боломж ахин олдсон юм. Шинжилгээний ажилд дав дээр хэрэг болох зүйлээ бүрдүүлэн 12-р сарын дунд үест Цагааннуур сумын нутгийг зорин очлоо.

Нутгийн хүмүүсийн дэмжлэгтэйгээр уг бичээст хэдыг мэдэж болох хэд хэдэн хүнтэй уулзав. Харамсалтай нь эдгээр нөхөд тэр бичигт хэдыг нарийвчлан үзээгүй (зарим нь уг хад хаана байгааг ч төдий л тодорхой хэлж чадахгүй байлаа), иймээс ч тэнд ямар бичиг байгааг нарийн мэдэхгүй учраа «ний нуугүй» ярьцгааж байв. Хүмүүсийн ярианаас үзвэл энэ тухай сангийн аж ахуйн орлогч дарга Дашдорж мэдэж болох юм гэж ойлголоо. Дашдоржтой уулзвал «Хэдэн жилийн өмнө би тэр чулууг үзсэн. Энэ бол Тэнгэсийн голд биш, түүнээс цааш, Харанга ойн аманд бий. Миний очсон үе бол намар цаг байсан. Энэ чулуу усан дотор буй тул нарийвчлан үзэх боломж байгаагүй. Ямарч байсан түүн дээр зураг бий» гэв. Дашдорж дарга харин «шинжлэх

1 Уг шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, урлаг судлалын ухааны дэд эрдэмтэн А. Сономцэрэн, Ж.Энэбиш нар оролджээ.

ухааны тусын тулд» газарчлан явахад татгалзахгүй гэдгээ мэдэгдэв. Ингээд бичигт хад хүртэл цааш хамтдаа явах болов.

1. Уг бичээс Цагааннуур сумын төвөөс баруун хойт чигт орших бөгөөд бид бичээст хад хүрэхийн тулд Их Саригийн ам хүртэл машинаар явцгаав. Сумын төвөөс энэ хүртэл яг 40 км газар байв. Нутгийн хүмүүсийн ярианаас үзвэл Шишгидийн гол харзалсан учир бичигт хад хүртэл цааш 30—35 км газар мориор явах шаардлагатай гэнэ. Тэр хавийн айлаас (Цагааннуур сумын адуучин Б. Баасжий гэдгээс) морь гуйж анчин А. Бат, сангийн аж ахуйн орлогч дарга Дашдорж нарын хамт яаравчлан явсан боловч бид тэр өдөртөө бичигт хаданд хүрч чадалгүй Ринчинлхүмбэ сумын 11 бригадын нутаг Алаг хад гэдэг газар хүрч хоньчин Гомбын Найдан гэдэг айлд хоноглов. 30-аадхан км газар өдрийн хагасад яваад хүрчихэж болох мэт нөхдөд санагдаж байгаа байх. Чухам тэр үед би ч гэсэн тэгж санаж байлаа. Гэтэл явах зам бартаатай, үүн дээр Тэнгэс, Живлэг, Шишгэд голууд харзтай, түүнийг тойрч явсан нь бидний аялах замын цагийг үнэхээр 4-5 цагаар уртасгасан юм. Энэ үесэд «зуны улиралд уул бичигт хаданд хүрэх боломжгүй» гэж хоёр жилийн өмнө С. Банзрагч гуайн хэлсэн нь үнэн юм гэж өөрийн эрхгүй бодогдлоо. Ингээд маргааш өглөө нь бичигт хадандаа хүрэв.

Уг хад бол Цагааннуур сумын төвөөс баруун хойш 70—75 км зайтай, Ринчинлхүмбэ сумын 11 (Тарган нуур) бригадын нутагт Шишгэд голд цутгасан Харанга ой голын аманд, Хээргийн боом гэдэг хадан хясааны дээд талд, доод Тошдог уулын ар талд байна. Бичиг бүхий чулууг нутгийн цаатан, дархад нар Орюк хад гэж нэрлэдэг бөгөөд дээр үед «нутгийн нэгэн хулгайч залуу адуу хулгайлан, тэнд аваачин шарж идээд, адууныхаа цусаар уг чулуунд бичиг бичсэн. Иймээс уг чулууг тэр хүний нэрээр нэрлэх болсон»¹ гэнэ. Гэвч энэ үгийг цаатан хэлний «хэнз, давжаа» гэдэг үгтэй холбон үзэж бас болох юм.

Алаг хад, Доод Тошдог, Хээрийн боомны хадан цохио зэрэг ойр хавийнх нь хадтай харьцуулбал энэ бол үнэхээр орюк «хэнз, давжаа» гэдэг нэрэндээ тохирсон мэт санагдана.

2. Орюк хад нь өндрөөрөө (голын усны төвшнөөс дээш) 7,5 м, өр гөн нь 3 м, зузаан нь 2 м орчим бөгөөд голын хөвөөнөөс 4 м дотогш, усан дунд, 80 градус орчим урсгалаа сөрж бөхийсөн байна. Бичээсийг чулууны дунд хирд (усны төвшнөөс 3,5 м дээш) хоёр хэсэг газар нийтдээ 4 мөр болгон бичжээ.

Нэгдүгээр хэсэг буюу уг чулууны баруун талд бичсэн хоёр мөр бичээсийн 1-р мөрийн үсгийн өндөр 2,2 см, урт нь 18,5 см, 2-р мөрийн үсгийн өндөр 2,5 см-5,0 см, нийт мөрийн урт 27,5 см, энэ хоёр мөрийн хоорондох зай мөрийн эхний хэсэгт 2,5 см, сүүл хэсэгтээ 3,5 см байна.

Хоёрдугаар хэсэг буюу уг чулууны зүүн талд бичсэн бичээс нь мөн хоёр мөрөөс бүрдэх бөгөөд нэгдүгээр мөрний бичээсийн үсгийн өндөр 2,5-3,0 см, хоёрдугаар мөрний үсгийн өндөр 3,5-4,0 см байна. Уг бичээсийг нийтэд нь Күли-тегин, Тонькук зэрэгт зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээс шиг ухаж бичсэн биш, харин хурц үзүүртэй зүйлээр зурж бичсэн учир үсгийн гүний хэмжээний талаар ярих боломжгүй юм.

1 Уг домгийг Хөвсгөл аймгийн Цагаан нуур сумын адуучин, 49 настай Б.Баасжий ярив.

Бичээсийн үсэг-зурлагыг үзүүлбэл
Нэгдүгээр хэсгийн бичээс (А)

Хоёрдугаар хэсгийн бичээс (Б)

3. Нэгдүгээр хэсгийн нэгдүгээр мөрөнд нийт 14 үсэг орсны 10 үсэг нь их л тод байна. Эдгээрээс $\frac{o}{y}$ пл-ийн ард орсон дөрвөн балархай Үүний эхний хоёр үсгийг зурлагын төстэй байдал дээр үндэслээд чанга гийгүүлэгч байх гэж ухаарав.

Харин дараагийн хоёр үсэг мөн балархай боловч үүнийг (2) м хоёр үсэг өмнөх балархай үсэгтэй нийлж нэг үг болно гэж үзвэл энэ үг нь үйл, гэхдээ өнгөрсөн цагт нэгдүгээр биед хамаатай, өөрөөр хэлбэл энд буй сул гийгүүлэгч-д (2) нь эртний түрэг хэлнээ өнгөрсөн цаг заах -ты -ти, -ды -ди гэдэг дагаврын -ди гэсэн сул хувилбар, -м нь уг үйл нэгдүгээр биед хамаатайг заах дагавар гэж ухаарч байна.

Эдгээрээс хойш тусгаарлах тэмдэг хүртэлх нийт дөрвөн үсэг нь з бүгд сул эгшиг, гийгүүлэгч тул нийлээд нэг үг болох юм.

Нэгдүгээр мөрний сүүлийн гурван үсгийн нэг нь чанга гийгүүлэгч байна

Дээр өгүүлсэн тайлбарт түшиглэн энэ мөрний үсэг зурлагыг үс гээр тэмдэглэвэл:

$\frac{o}{y}$ пл/1/й/2/ р/2/д/2/м $\frac{и}{ьг}$ р/2/г/2 $\frac{о}{y}$: к/1/ч $\frac{а}{о}$

Нэгдүгээр хэсгийн хоёрдугаар мөрөнд нийт 14 үсэг, 2 тусгаарлах тэмдэг орсон байна. Энэ мөрөнд ганц үсгээс бусад нь нэлээд тодорхой. Иймд эдгээрийг үсэгчлэн галиглах нь тийм ч хүнд биш байна.

л/1/п $\frac{y}{о}$ ж нн, чн/1/к/2/ $\frac{о}{y}$ р/2/ г /2/ л /2/ ик /2/

Хоёрдугаар хэсгийн буюу уул хадны хойт хэсэгт мөн хоёр мөр бичээстэй. Үүний нэгдүгээр мөрөнд нийт 19 үсэг, хоёр тусгаарлах

тэмдэг байна. Эдгээр үсгүүдийн гэмтэл бага. Иймд үүнийг шууд үсэгчилэн галиглавал:
 л /1/ у йыл/1/т/2/ $\frac{о}{у}$ р/2/ к/2/ б/1/ $\frac{о}{у}$ йл/1/й т/1/р/1/к/1/н/1/к/2/

Хоёрдугаар хэсгийн хоёрдугаар мөрөнд буй нийтдээ арван нэгэн үсэг орсон боловч ихэнх нь гэмтэж баларсан, тэдгээрийг сэргээн унших аргагүй болжээ.

. чл/1/ л/1/ б/2/ н/2/

4. Зарим үгийн хэл зүй, үгсийн сангийн тайлбар.

$\frac{о}{у}$ пл/1/й/2 гэдэг үсгийг үгийн галигт шилжүүлбэл оплайу опла «бросаться в атаку (ДТС. 368)

» + йу (~и) «нөхцөл үйл үгийн хэлбэр» Энэ үг яг ийм хэлбэрээрээ БНМАУ-ын нутагт буй түрэг бичээст тохиолдож байна. Ж нь: **Күли-тигин йадагын онлайн тегди** (Кт, и, 32) «Күл тегин явганаар довтольё гэв», Күли-тор онлайну тегип (Кч.10) «Чүли-чор довтлон хүрч» г.м.

-р /2/д /2/м -ердим гэдэг үг нь яг энэ хэлбэр, утгаараа дээр дурьдсан бичээст ер тохиолдохгүй байна,

Хоёр бүтээврээс үүссэн /түүхэн үүднээс бол гурван (!)/ энэ үгийн -дм нь бол Орхоны бичигт олонтоо тохиолддог тухай өмнө өгүүлсэн билээ. Харин язгуур-үндэс болсон (үндэс нь энд «О» морфемоор илэрч байна) ер нь «следовать, преследовать (ДТС. 175) » гэсэн утгатай. Бидний бодоход уул үг нь манай судалж байгаа бичээст гарч байгаа ер гэдэг үйл үг мөн биз ээ! -Дим (ди +м) гэдэг нь үйл үгийн өнгөрсөн цагийн хэлбэр, гэхдээ нэгдүгээр биеийн ганц тоонд хамаатайг илтгэсэн хэлбэр юм. Ийм хэлбэр энд бидний харьцуулан үзэж, баталгаа болгон ашиглаж байгаа БНМАУ-ын нутагт буй түрэг бичээст олонтоо тохиолдоно.

Жнь: . . .**кышын кытан тапа сүледим** (Б.Ха.2) «өвөл нь кыдан руу цэрэглэв би» Иегинимин атымын көртим (С.8) «Ач үрээ үзлээ би» г.м. **Билге Тонькук бен өзүм табгач илинге кылынтым** (Т,7). «Цэцэн Тонькук би өөрөө Табагач улсад хүмүүжив би», **Биргэрү токуз ерсэнкетеги сүледим, Түпүтке кичиг тегмедим** (Кт.б.3). «**Урагшаа мөн ерсөнд хүртэл цэрэглэв. Түвдэд арайхан хүрсэнгүй би**». Эдгээр өгүүлбэрт өгүүлэхүүний харьцааг илэрхийлж буй үйл үгийн хэлбэржилттэй дээр бидний өгүүлсэн ердим гэдэг үг адил хэлбэржилттэй байна. $\frac{и}{ы}$ р/2/ г/2/ $\frac{о}{у}$ -Ирегү нь мөн Орхон бичээст тохиолдохгүй боловч

бидэнд тодорхой мэдэгдэж байгаа **кача** үүний кач гэдэг нь «убегать бежать (ДТС.400) гэсэн утгатай үйл үг, -а нь одоо цагт болох нөхцөл үйл үгийн дагавар. Энэ дагавар нь түрэг бичээст олон тохиолдоно. Ж нь: **аша** гэвэл давж (Т.37), **йана** гэвэл эргэн эргэж (МЧ.5), **йүре** гэвэл зорчиж (МЧ16) г.м.

Энэ үг нь өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүн харьцааг (мөн гол ба гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүн харьцааг илэрхийлэх учир бидний бодлоор бол урьдах үг нь өгүүлэгдэхүүн гишүүн харьцааг заасан үг байх ёстой болж байна. Үлгэрлэвэл Онгины бичээст **сүси келти карасын йыгдым, беги качлы** «цэрэг нь ирэв, эгэл ардыг цуглуулав би, бэг (үүд) нь зугтав», гэдэгтэй адил юм. Иймээс сул эгшиг, гийгүүлэгчээс бүтсэн энэ үгийг бид **ергү** (?) гэдэг үг, энэ нь ер «байх орших» + гү «үйлээс нэр үүсгэх дагавар (ДТС. 654) » гэ-

сэн хоёр бүтээврээс үүссэн нэр үг, оршин суугч, оршин байх газар гэсэн утгатай, бидний энэ бичээст оршин суугчид нь, тэнд байгсад нь гэсэн утгатай орсон байх.

-н нүч $\frac{o}{y}$ н -ынанчун ынынчун: Бидний бодоход уг үг нь Күли Тегинд зориулан босгосон их бичээсийн 53-р мөрөнд буй ынанчу (**-ынанчучур-«Кырк-аз каганга тардуш ынанчу чур келти-дөчин азын улсаас тардуш ынанчу чур ирлээ»**) гэдэг үгтэй холбоотой байх. Үгийн гарал судлалын үүднээс бол энэ үг нь ынанч «вера, доверие, доверенный, должный (ДТС. 218)», **ынанчлыг ынанчлык** «верный (мөн тэнд 219)», ынанчсыз «неверный (мөн тэнд)» гэдэг үгстэй нэг гаралтай (түүгээр ч барахгүй нэг үндэстэй) үг юм.

Хоёрдугаар хэсгийн нэгдүгээр мөрнөөс бидний анхаарлыг татах үг бол т /2/ $\frac{o}{y}$ р /2/к/2/ б/1 $\frac{o}{y}$ -й /2/л/1 $\frac{a}{e}$ т/1/р/1/к/1/н/1/ **-түрк**

бойла таркан гэдэг үг юм. **Таркан** нь цол бөгөөд, энэ үг Хөл Асгатын бичээст **Алтан Тамган тархан** гэдэг холбоо үгээр тохиолдох бөгөөд бусад бичээст /**тухайлбал Билге Тоньук бойла таркан бирле Илтерис каган болайын** (Т.6) «Цэцэн Тоньук би бойла таркантай хамт Илтерис хаан болоосой гэж хүснэ)», . . . **ант Бойла** «тэнд Бойла. . . (МЧ.6) **Бойла бага Таркан улайу** (Мха-14) «Бойла бага Таркан удирдан, .. гэсэн холбоо үгээр гарч байна. Энд бидний өгүүлж буй Бойла таркан бол энэ үгтэй холбоотой юм.

5 Дээрх тайлбарт түшиглэн уг бичээсийн үсэг зурлагыг үгчлэн галиглавал:

А. 1. **оплайу ердим. ергү кача. .**

2 **алп уже ынанчун көруглик**

Б. 1. **лу йыл түрк бойла таркан кү**

2.

6. Монгол хэлээр орчуулбал:

А. 1. довтлон хөөлөө би (тэнд оршигчид нь (?) зугатаж ...

2. баатар дээд ынанчу (үнэнч Л.Б.) харуултай

Б. 1. луу жил түркийн бойла тарканы алдар

2.

Эртний түрэг бичээсийн дурсгалын ийм нэгэн олдвор нь түрэг ба монгол судлаачдын шинжилгээ судалгаанд нэмэр болж, түүхчдийн сонирхлыг татах нь эргэлзээгүй.